

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
218 дугаар тогтоолын 28 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын
газрын Халдварт бус өвчний хэлтэс

Албан тушаалын нэр:

Осол гэмтэл, хүчирхийлэл, жендэрийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендэрийн бодлого төлөвлөлт,
хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө
хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Осол гэмтлийн сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого боловсруулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах
2. Хүчирхийллээс сэргийлэх, хянах бодлогын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;
3. Жендэрийн тэгш байдлын бодлогын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;
4. Эмзэг бүлгийн хүн ам, ахмад настны эрүүл мэнд, хүүхэд хамгааллын чиглэлээр үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний урт, дунд, богино хугацааны бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангаж, тайлагнах;
5. Харшлаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах;
6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг хангах, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
7. Хариуцсан асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааг хангах, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бүрдүүлэх, хүлээлгэн өгөх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах	Төсөл нь хуульд нийцсэн хэл зүй найруулгын алдаагүй ойлгомжтой боловсруулсан байна.	Г
		Хэрэгжилтийг ханган холбогдох тайлан мэдээллийг гаргасан байна.	Г
	2.Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад удирдлагаар хангах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах	Хууль тогтоомжийн хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г
		Хяналт тавьж, хэрэгжилтийн тайлан гарсан байна	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хүчирхийллийн асуудлаарх бодлогыг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах	Төсөл нь хуульд нийцсэн хэл зүй найруулгын алдаагүй ойлгомжтой боловсруулсан байна. алдаагүй ойлгомжтой боловсруулсан байна.	Г

		Хэрэгжилтийг ханган холбогдох тайлан мэдээллийг гаргасан байна.	Г
	2.Хүчирхийллийн чиглэлээр арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах	Хууль тогтоомжийн хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г
		Хяналт шалгалтын хуулийн дагуу хяналт тавьж, хэрэгжилтийн тайлан гарсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Жендэрийн асуудлаарх бодлогыг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах	Төсөл нь хуульд нийцсэн хэл зүй найруулгын алдаагүй ойлгомжтой боловсруулсан байна.	Г
		Хэрэгжилтийг ханган холбогдох тайлан мэдээллийг гаргасан байна.	Г
	2.Жендэрийн чиглэлээр хөтөлбөр, үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих	Хууль тогтоомжийн хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г
		Хяналт шалгалтын хуулийн дагуу хяналт тавьж, хэрэгжилтийн тайлан гарсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Эмзэг бүлгийн хүн амын чиглэлээр салбар хоорондын болон олон улсын хамтын ажиллагааны нэгдсэн зохицуулалт хийх, хяналт тавих	Салбарын болон салбар хоорондын хамтын ажиллагаа өргөжиж, оролцоог хангуулах, хяналт тавьсан байна.	Г
	2.Хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн болон ТББ, ОУБ-уудтай хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах	Хамтын ажиллагаа өргөжсөн, оролцоог хангасан байна.	Г
	3.Ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр төрийн болон ТББ, ОУБ-уудтай хамтран ажиллах, салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах	Хамтын ажиллагаа өргөжсөн, оролцоог хангасан байна.	Г

5 дугаар зорилтын хүрээнд	1.Харшлаас сэргийлэхэд чиглэсэн бодлого эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Хууль тогтоомж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна	Г
	2.Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж, хүн амын мэдлэгийг дээшлүүлэх	Тайлбар, лавлагаа, зөвлөмж нь хуульд нийцсэн байх, мэдээлэл бодитой байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Тухайн асуудлын чиглэлээр эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, олон улсын конвенцийн хэрэгжилтийн тайлагналт, тухайн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт хийх, хяналт тавих;	Хамтын ажиллагаа өргөжсөн, оролцоо хангагдсан байна.	Г, Х
7 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж, дүгнэсэн байна.	Г
	2.Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;	Мэдээлэл, мэргэжил арга зүйн туслалцаа нь хууль, тогтоомжинд нийцсэн бодитой байна.	Г,Т
	3.Архив, албан хэрэг хөтлөлт, тайлан, мэдээг цаг тухайд нь тайлагнах, хяналт тавих;	Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Г
	4.Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн байна.	Г,Т
	5.Нэгжид ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулалтад хяналт тавих	Шийдвэрлэх үйл ажиллагаа хуульд нийсэн байна.	Х, Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- эрүүл мэнд /091/; - нийгмийн эрүүл мэнд /098801/;		
Мэргэшил			

Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;

		- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах; - бусад.
IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>		
Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчний хэлтэс		
<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u>	
	- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан тушаалтан; - ОУБ-ын төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан; - Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.	
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>	
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА /Б.БАТБАЯР/ 2025 оны дугаар сарын -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 25 05 21 <u>Дугаар:</u> 218	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:		
<u>Байгууллагын нэр:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /Д.ОЧИРБАТ 2025 оны дугаар сарын -ны өдөр		